



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/42/НА-СТА-ТЗШ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Мөрөн сум 2023 он</p>	<p>Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар Утас:88883317 Цахим хаяг: Erdenebaatar@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Б.Давааням Утас: 88095436 Цахим хаяг: Davaanyamb@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Д.Отгонбаяр Утас: 89306788 Цахим хаяг: Otgonbayarde@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Хөвсгөл аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	4
Асуудлыг онцолсон хэсэг.....	4
Аудитын гол асуудал.....	5
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	13
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.2 Материаллаг байдал.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ...	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	18
4.5.1 Завсрын аудитын талаар .....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	19

Хөвсгөл аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХАХНХ	Хүн амын хөгжил,нийгмийн хамгаалал



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2023.08.24 № 01/188  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН АХМАД НАСТНЫ  
АСРАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН  
ДАРГА Т.ОКТЯБРЬБАЯР ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Ахмадын асрамж, үйлчилгээний төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Ахмад настны асрамж, үйлчилгээний төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Ахмадын асрамж, үйлчилгээний төвийн жилийн төсвийн 63.1 хувийг цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал болон ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн зардал эзэлж байна.

### Аудитын гол асуудал

Тухайн байгууллагын удирдлагын буруу шийдвэрээс болж шүүхийн шийдвэрээр буцаан томилсон ажилчдын цалин 14,996.5 мянган төгрөгийн авлага үүсгэсэн болно.

### Бусад асуудлын хэсэг

Ахмад настны асрамж, үйлчилгээний төв нь тайлант онд хэрэгжүүлэхээр нийт 4 зорилт 41 арга хэмжээг төлөвлөж 90 хувь хэрэгжүүлж ажилласан гэж дүгнэсэн байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР



Хөвсгөл аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>72,321,721.24</b>	<b>75,035,111.00</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>00.00</b>	<b>14,966,517.00</b>
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	<b>00.00</b>	<b>14,966,517.00</b>
3352	Хувь хүмүүсээс авах авлага	00.00	14,966,517.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>72,321,721.24</b>	<b>60,068,594.00</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>11,302,724.00</b>	<b>10,968,624.00</b>
35130	Эм боох материал	11,302,724.00	10,968,624.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>61,018,997.24</b>	<b>49,099,970.00</b>
35410	Бичиг хэргийн материал	17,700.00	00.00
35420	Аж ахуйн материал	36,498,080.00	44,120,180.00
35460	Хүнсний материал	18,932,784.74	286,290.00
35470	Бусад хангамжийн материал	5,570,432.50	4,693,500.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>122,414,791.66</b>	<b>123,908,845.70</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>122,414,791.66</b>	<b>123,908,845.70</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>52,114,791.66</b>	<b>53,055,145.70</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	65,048,781.00	65,048,781.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-37,909,258.92	-50,545,678.56
39203	Авто-тээврийн хэрэгсэл	00.00	9,300,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	31,724,900.00	31,745,900.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-7,477,408.34	-7,346,566.72
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	7,460,615.00	6,343,320.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-6,732,837.08	-1,490,610.02
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>70,300,000.00</b>	<b>70,853,700.00</b>
39301	Програм хангамж	992,000.00	553,700.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-992,000.00	00.00
39303	Бусад биет бус хөрөнгө	70,300,000.00	70,300,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>194,736,512.90</b>	<b>198,943,956.70</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>00.00</b>	<b>2,213,489.44</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>00.00</b>	<b>2,213,489.44</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>00.00</b>	<b>2,213,489.44</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	680,362.71
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	1,533,126.73
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>194,736,512.90</b>	<b>196,730,467.26</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>194,736,512.90</b>	<b>196,730,467.26</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	194,236,436.00	194,236,436.00
51101	Өмч: - төрийн	194,236,436.00	194,236,436.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>-12,323,069.22</b>	<b>-10,203,032.86</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-12,323,069.22	-12,196,987.22
51220	Тайланг үеийн үр дүн	00.00	1,993,954.36
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	12,823,146.12	12,697,064.12
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>194,736,512.90</b>	<b>198,943,956.70</b>

Хөвсгөл аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>549,382,980.00</b>	<b>513,702,570.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>26,642,280.00</b>	<b>15,544,370.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>26,642,280.00</b>	<b>15,544,370.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	26,642,280.00	15,544,370.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	26,642,280.00	15,544,370.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>522,740,700.00</b>	<b>498,158,200.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>38,522,300.00</b>	<b>56,761,600.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,000,000.00	10,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	28,522,300.00	46,761,600.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>484,218,400.00</b>	<b>441,396,600.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	484,218,400.00	441,396,600.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>514,704,110.40</b>	<b>509,915,615.64</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>514,704,110.40</b>	<b>509,915,615.64</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>455,976,096.73</b>	<b>501,098,033.87</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>238,969,859.94</b>	<b>233,651,164.20</b>
210101	Үндсэн цалин	238,969,859.94	196,583,608.20
210102	Нэмэгдэл	00.00	35,352,120.00
210104	Урамшуулал	00.00	1,715,436.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>30,753,201.07</b>	<b>30,740,220.94</b>
210201	Тэтгэврийн даатгал	21,454,164.06	20,341,406.48
210202	Тэтгэмжийн даатгал	2,427,663.81	3,327,844.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,911,757.34	1,916,914.21
210204	Ажилгүйдлийн даатгал	450,874.62	468,549.87
210205	Эрүүл мэндийн даатгал	4,508,741.24	4,685,505.45
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>34,650,594.12</b>	<b>33,156,940.33</b>
210301	Гэрэл, цахилгаан	8,013,651.00	8,289,611.29
210302	Түлш, халаалт	18,383,079.80	18,231,279.00
210303	Цэвэр, бохир ус	8,253,863.32	6,636,050.04
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>16,014,540.00</b>	<b>18,812,139.00</b>
210401	Бичиг хэрэг	802,290.00	1,437,630.00
210402	Тээвэр, шатахуун	928,200.00	1,587,360.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	358,200.00	216,290.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	198,100.00	185,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, эхуйн эд зүйлс	13,727,750.00	15,385,159.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>108,359,275.96</b>	<b>140,869,103.44</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,842,986.00	6,713,068.80
210502	Хоол, хүнс	85,847,672.46	117,632,081.14
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	15,668,617.50	16,523,953.50
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>10,491,110.00</b>	<b>25,099,500.00</b>

Хөвсгөл аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210604	Урсгал засвар	10,491,110.00	25,099,500.00
2107	Томилолт, зочны зардал	100,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	100,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,219,140.00	580,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,844,500.00	148,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	346,500.00	432,000.00
210807	Газрын төлбөр	28,140.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,418,375.64	18,188,965.96
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	14,418,375.64	18,188,965.96
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58,728,013.67	8,817,581.77
2132	Бусад урсгал шилжүүлэг	58,316,200.00	8,817,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	55,211,200.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,105,000.00	8,817,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	411,813.67	581.77
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	411,813.67	581.77
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	34,678,869.60	3,786,954.36
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	6,261,000.00	1,793,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145- 225)	-6,261,000.00	-1,793,000.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	28,417,869.60	1,993,954.36

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	522,740,700.00	498,158,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	293,716,800.00	498,158,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	38,522,300.00	56,761,600.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,000,000.00	10,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	28,522,300.00	46,761,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	484,218,400.00	441,396,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	484,218,400.00	441,396,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	522,740,700.00	491,771,550.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	522,740,700.00	491,771,550.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	464,012,686.33	482,953,968.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	238,969,859.94	247,840,099.20
210101	Үндсэн цалин	238,969,859.94	210,772,543.20
210102	Нэмэгдэл	00.00	35,352,120.00
210104	Урамшуулал	00.00	1,715,436.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,753,201.07	30,837,440.23
210201	Тэтгэврийн даатгал	21,454,164.06	20,438,625.77

Хөвсгөл аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210202	Тэтгэмжийн даатгал	2,427,663.81	3,327,844.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,911,757.34	1,916,914.21
210204	Ажилгүйдлийн даатгал	450,874.62	468,549.87
210205	Эрүүл мэндийн даатгал	4,508,741.24	4,685,505.45
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>34,650,594.12</b>	<b>32,744,200.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	8,013,651.00	8,289,611.29
210302	Түлш, халаалт	18,383,079.80	18,231,279.00
210303	Цэвэр, бохир ус	8,253,863.32	6,223,309.71
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>15,963,940.00</b>	<b>16,474,960.00</b>
210401	Бичиг хэрэг	819,990.00	1,419,930.00
210402	Тээвэр, шатахуун	668,200.00	1,587,360.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	358,200.00	216,290.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	198,100.00	185,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,919,450.00	13,065,680.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>119,913,941.20</b>	<b>122,145,768.80</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	13,711,990.00	7,012,668.80
210502	Хоол, хүнс	92,999,901.20	97,183,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	13,202,050.00	17,950,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>17,165,110.00</b>	<b>32,199,500.00</b>
210602	Тавилга	6,000,000.00	7,100,000.00
210604	Урсгал засвар	11,165,110.00	25,099,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>100,000.00</b>	<b>00.00</b>
210702	Дотоод албан томилолт	100,000.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>6,496,040.00</b>	<b>712,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,121,400.00	280,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	346,500.00	432,000.00
210807	Газрын төлбөр	28,140.00	00.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>34,919,670.00</b>	<b>8,817,581.77</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>58,728,013.67</b>	<b>8,817,000.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	55,211,200.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,105,000.00	8,817,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>411,813.67</b>	<b>581.77</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	411,813.67	581.77
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>00.00</b>	<b>6,386,650.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>00.00</b>	<b>6,386,650.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>6,386,650.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>00.00</b>	<b>6,386,650.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	6,386,650.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>00.00</b>	<b>-6,386,650.00</b>

Хөвсгөл аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

					Төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	123,936,436.00	3,210,167.00	-28,149,916.88	98,996,686.12
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	123,936,436.00	3,210,167.00	-28,149,916.88	98,996,686.12
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	4,532,032.75	4,532,032.75
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	194,236,436.00	12,823,146.12	-12,323,069.22	194,736,512.90
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	194,236,436.00	12,823,146.12	-12,323,069.22	194,736,512.90
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	126,082.00	126,082.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	194,236,436.00	12,823,146.12	-12,196,987.22	194,862,594.90
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-126,082.00	00.00	-126,082.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,993,954.36	1,993,954.36
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	194,236,436.00	12,697,064.12	-10,203,032.86	196,730,467.26

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

						Төгрөгөөр/
Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		.			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	441,396,600.0	441,396,339.4	260.6	100.0	

**Хөвсгөл аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	441,396,600.0	441,396,339.4	260.6	100.0
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	441,396,600.0	441,396,339.4	260.6	100.0
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	247,840,100.0	247,840,099.2	00.8	100.0
210101	Үндсэн цалин	202,407,600.0	210,772,543.2	-8,364,943.2	104.1
210102	Нэмэгдэл	45,432,500.0	35,352,120.0	10,080,380.0	77.8
210104	Урамшуулал	00.0	1,715,436.0	-1,715,436.0	
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	30,837,700.0	30,837,440.2	259.8	100.0
210201	Тэтгэврийн даатгал	20,819,400.0	20,438,625.8	380,774.2	98.2
210202	Тэтгэмжийн даатгал	2,909,700.0	3,327,844.9	-418,144.9	114.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,903,000.0	1,916,914.2	-13,914.2	100.7
210204	Ажилгүйдлийн даатгал	473,300.0	468,549.9	4,750.1	99.0
210205	Эрүүл мэндийн даатгал	4,732,300.0	4,685,505.5	46,794.5	99.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	32,744,200.0	32,744,200.0	00.0	100.0
210301	Гэрэл, цахилгаан	7,734,300.0	8,289,611.3	-555,311.3	107.2
210302	Түлш, халаалт	17,701,500.0	18,231,279.0	-529,779.0	103.0
210303	Цэвэр, бохир ус	7,308,400.0	6,223,309.7	1,085,090.3	85.2
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	12,254,500.0	12,254,500.0	00.0	100.0
210401	Бичиг хэрэг	1,420,000.0	1,419,930.0	70.0	100.0
210402	Тээвэр, шатахуун	1,059,000.0	1,059,000.0	00.0	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	216,200.0	216,290.0	-90.0	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	185,700.0	185,700.0	00.0	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,373,600.0	9,373,580.0	20.0	100.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	116,591,600.0	116,591,600.0	00.0	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,458,500.0	1,458,500.0	00.0	100.0
210502	Хоол, хүнс	97,183,100.0	97,183,100.0	00.0	100.0
210503	Нормын хузцас, зөөлөн эдлэл	17,950,000.0	17,950,000.0	00.0	100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	416,500.0	416,500.0	00.0	100.0
210604	Урсгал засвар	416,500.0	416,500.0	00.0	100.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	712,000.0	712,000.0	00.0	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	280,000.0	280,000.0	00.0	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	432,000.0	432,000.0	00.0	100.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	441,396,600.0	441,396,339.4	260.6	100.0
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	441,396,600.0	441,396,339.4	260.6	100.0

**Хөвсгөл аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

132001	Орон нутгийн төсвөөс	441,396,600.0	441,396,339.4	260.6	100.0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	26.00	26.00	00.00	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	09.00	09.00	00.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	16.00	16.00	00.00	100.0

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Гүйцэтгэл	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>56,761,278.80</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>56,761,278.80</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>47,944,278.80</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		<b>4,220,460.00</b>
210402	Тээвэр, шатахуун		528,360.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		3,692,100.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>		<b>5,554,168.80</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		5,554,168.80
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		<b>38,169,650.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл		3,500,000.00
210602	Тавилга		9,986,650.00
210604	Урсгал засвар		24,683,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>8,817,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		<b>8,817,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		8,817,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>56,761,278.80</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		<b>56,761,278.80</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		10,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		46,761,278.80
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		<b>00.00</b>
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		00.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хөвсгөл аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төв нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа ахмад настанд төрөлжсөн асрамжийн үйлчилгээг стандартын дагуу хүргэж, ганц бие, тэжээн тэтгэх үр хүүхэд, төрөл садангүй нийгмийн халамж, дэмжлэг зайлшгүй шаардлагатай ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хүрч үйлчлэх, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэх, хууль тогтоомжийн дагуу хууль ёсны эрх ашгийг хамгаалж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг стандартын дагуу үзүүлэх чиг үүрэгтэй байгууллага юм.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

**Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:** Хөвсгөл аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төв нь үйл ажиллагаандаа дараах хууль эрх зүйн орчныг мөрдлөг болгон ажиллаж байна.

- Ахмад настны тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Нийгмийн даатгалын тухай хууль гэх мэт бусад хууль тогтоомжууд.

Тайлант онд тухайн байгууллагад мөрдөгдөх дараах хууль тогтоомжуудад өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

1. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-ээс хэрэгжиж эхэлсэн.
2. Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн "Төрийн хэмнэлтийн тухай" хууль хэрэгжиж эхэлсэн.
3. Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоосон ба 2022 оны 192 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Байгууллагын даргын 2022 оны А/16 дугаар тушаалаар 3 хүний бүрэлдэхүүнтэй дотоод хяналтын нэгж томилон ажиллуулж байна. Дотоод хяналтын нэгж нь үйл ажиллагааны төлөвлөгөө батлуулж, төлөвлөгөөний дагуу хяналт хэрэгжүүлж, үр дүнг тайлагнан ажилладаг байна.

Харин санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтын 1, 2 үе шатны тогтолцоо бий болсон байна гэж үзлээ. **Тухайлбал:** Санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэх удирдлага буюу

Хөвсгөл аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

дарга 1 дүгээр гарын үсэг, нягтлан бодогч 2 дугаар гарын үсэг зурж баталгаажуулж байгаа нь гүйцэтгэх удирдлагын хяналтыг хэрэгжүүлж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Дотоод аудитын нэгжийн чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккурэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын даргын 2019 оны А/06 тоот тушаалаар баталсан бодлогын баримт бичгийг батлан мөрдөж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөвсгөл аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,207.4 мянган төгрөгөөр буюу 2.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган

төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага		14,966.5	14,966.5
Бараа материал	72,321.7	60,068.6	-12,253.1
Үндсэн хөрөнгө	122,414.8	123,908.8	1,494.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>194,736.5</b>	<b>198,943.9</b>	<b>4,207.4</b>
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	194,736.5	196,730.5	1,994.0
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>194,736.5</b>	<b>198,943.9</b>	<b>4,207.4</b>

Дээрх хүснэгтээс харахад авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос 14,966.5 мянган төгрөгөөр өссөн нь үндэслэлгүйгээр ажлаас чөлөөлөгдсөн 2 ажилтанд шүүхийн шийдвэрийн дагуу ажилгүй байсан хугацааны цалинг нөхөн олгож, буруутай этгээдээр нөхөн төлүүлэхээр авлага бүртгэсэнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 570,162.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийг 118,302.6 мянган төгрөгөөр бууруулж, 451,859.7 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 10,463.1 мянган төгрөгөөр бууруулж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг 441,396.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөж, санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 441,396.3 мянган төгрөг буюу 99.99 хувьтай байна.

Хүснэгт 2. Төсвийн гүйцэтгэл хөтөлбөр, арга хэмжээгээр

		/мянган төгрөгөөр/				
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт	
1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	315,564.4	315,564.1	0.3	99.99%	
2	71902 Нийгмийн халамж 80112 Нийтлэг үйлчилгээ	125,552.2	125,552.2	0	100%	
3	81103 Эрсдэлийн сангийн нөөц хөрөнгө	280.0	280.0	0	100%	
Нийт дүн		441,396.6	441,396.3	0.3	99.99%	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн 100170017401 тоот дансанд нийт 56,761.6 мянган төгрөгийн орлого орсон байна. Үүнээс:

- ❖ 10,000.0 мянган төгрөг нь Аймгийн ЗДТГ-аас хуваарилсан төсөв
- ❖ 46,761.6 мянган төгрөг нь асруулагчдын тэтгэвэр тэтгэмжийн 30 хувь. Асруулагчдын тэтгэвэр тэтгэмжийн 30%-ийн мөнгийг энэ дансанд төвлөрүүлдэг бөгөөд ХАХНХ-ын сайдын 2013 оны 10-р сарын 18-ны А/156 дугаар тушаалын хавсралт "Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа ахмад настан, 18

Хөвсгөл аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

ба түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тэтгэвэр олгох журам"-ын  
3.1.-д заасны дагуу зарцуулдаг байна.

Зарцуулалт:

1. Эм бэлдмэл, эмнэлгийн багаж хэрэгсэлд 5,554.2 мянган төгрөг,
2. Асруулагчдын амьдрах нөхцөлийг сайжруулах , өрөөг тохижуулах зорилгоор ахуйн хэрэглээний техник , төхөөрөмж авах, өрөөнүүдийн засвар үйлчилгээ хийхэд 32,390.1 мянган төгрөг,
3. Баяр ёслол тэмдэглэлт өдрүүдээр бэлэг, дурсгалд 8,817.0 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

Засаг даргын нөөц хөрөнгөнөөс хуваарилсан 10,000.0 мянган төгрөгийн нэмэлт төсвийг удирдлагын зөвлөлөөр хэлэлцэн, байгууллагын цахилгааны монтаж солих ажилд зарцуулсан байна.

Төвлөрүүлэг шилжүүлгээр 321.2 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

**3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах төсвийн зарцуулалттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Давааням, ахлах аудитор Д.Отгонбаяр нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Тэгшдэлгэр, газрын захирал, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 15 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 465,732.4 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 6,985.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илэрсэнгүй.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хөвсгөл аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн 2022 оны Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны мэдээллээс дараах мэдээллийг түүвэрлэн шалгалаа. Үүнд:

- Тендерт шалгарсан болон шалгараагүй талаарх товч мэдээлэл
- Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ
- Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл

Шилэн дансны дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзэхэд мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж ажилласан бөгөөд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллүүдийг хуулийн хугацаанд мэдээлсэн, 2022 онд зохион байгуулсан худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Хөвсгөл аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хэрэгжүүлээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар Засгийн газрын 43 дугаар тогтоол болон Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 2 зөвлөмж өгсөн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	62,217.2	2	62,217.2	100%
Нийт дүн	2	62,217.2	2	62,217.2	100%

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 14,966.5 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 14,966.5 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

Үүнд: Үндэслэлгүйгээр ажлаас чөлөөлөгдсөн 2 ажилтанд шүүхийн шийдвэрийн дагуу ажилгүй байсан хугацааны цалинг нөхөн олгосон боловч буруутай этгээдээр төлүүлэхээр авлага бүртгээгүй зардлаар хүлээн зөвшөөрч тайлагнасныг аудитын явцад залруулж авлагаар бүртгүүлсэн.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Авлага бүртгэлд тусгаагүй	1	14,966.5	1	14,966.5			1	14,966.5				
Дүн	1	14,966.5	1	14,966.5			1	14,966.5				

### АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

БАТАЛГААЖУУЛСАН:

АХЛАХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

Д.ОТГОНБАЯР ОГНОО

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,